

МОНГОЛ ХЭЛНИЙ ОРОН ЦАГИЙН ХАРЬЦААНЫ НЭРИЙН
ӨГҮҮЛБЭРТ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Ч. Бямбаханд *

Монгол судлаачдын бүтээлд орон цагийн харьцааны нэр нь хэлэхүүний цуваа бүтцэд орохдоо орон цагийн утгат үйлдэх ба өгөх орших, гарах, чиглэхийн тийн ялгалын нөхцөлийн ерөнхий утгыг тодруулахын үүднээс өмнөх үгээ дагалдан, хэлзүйжсэн хэлц холбоо үгийг бүтээвэл түүнийг “дагавар үг” (послелог, postposition) буюу “туслах үг” (служебное слова, syncategorematic), “хэлзүйн үг” (грамматические слова) гэх мэтээр нэрлэсээр иржээ. Жишээ нь, *Тэр шатаам наран доогуур; тэр унжилдсан шаргал униар дундуур; тэртээ зүүн дор; голын хөвөө тушаа нүргэлж буй тулалдааны чимээнээс холдож, нэгэн морь тэрэг баруун зүг гэлдрэн авай.* (С.Э) гэхэд “доогуур, дундуур, дор, тушаа” гэсэн орны нэр нь өмнөх жинхэнэ нэр (нар, униар, хаяа (зүг) хөвөө)-ийг дагалдан оржээ.

Үүнийг Ш.Лувсанвандан “Монгол хэлэнд бие даасан дагавар үг байна уу, үгүй юу гэдэг нь бас маргаантай асуудлын нэг юм. Одоогийн дагавар үг гээд байгаа нь “дээр, доор, гадна, дотор” гэх мэтийн орон цагийн харьцааны нэрийг заримдаа өмнөх үгтэйгээ хавсарч нэг нийлмэл ухагдахууныг заасан утгатай хэрэглэхийг хэлж байна. Гэтэл эдгээр “дээр, доор” гэх мэтийн үгс нь язгууртай, үндэстэй, тийн ялгалаар бүрэн ялгаллагдах үгс юм. Энэ учраас дээр дурдсан дагавар үг гэж үзэхэд бэрхтэй “-шиг” бүтээврийг орон цагийн харьцааны үгтэй нэг эгнээнд оруулах аргагүй юм.”¹ Ийнхүү орон цагийн харьцааны нэр өгүүлбэрт ямар үүргээр тохиолдож буйг жишээгээр авч үзье. Тухайлбал,

- *Лодой баян дотроо горьдохдоо ...* (Б.Р)

- *... гадна морины уяанд нэг морь уяатай байгааг заагаад ...* (Б.Р)

- *Ээж, би, тэр жил намайг муугаас муу, модноос хөө гээж хэлсний нь одоо хүртэл мартдаггүй юм шүү* (Б.Р)

- *Хуучин занги нь тэр дороо зангийн гуулин захирлага тэмдэг, хөх ваадантай бичиг хэргээ гардуулан тушааж өгсөн билээ* (Б.Р)

- *... сая нэг их тусалсан болж, сүр бадруулдаг нь юу ч билээ?* (Б.Р) гэх мэтээр “дотроо, гадна, одоо хүртэл, сая” гэх мэт орон цагийн харьцааны нэр нь өгүүлбэрт дангаараа бие даан захын дэлгэрүүлэгч гишүүн болсон байна.

Мөн түүнчлэн орон цагийн харьцааны нэр нь:

* МУИС, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

¹ Лувсанвандан Ш. Орчин цагийн монгол хэлний бүтэц. Монгол хэлний үг нөхцөл хоёр нь. Уб., 1968. 53-54-р т.

-Хурлын сүүлээр Лодой баян Чулууны дэргэд ирээд олны нүүрэн дээр нь магтан ... (Б.Р).
 -Лодой баян, бэйсийг үг хэлсний дараа өвгөн Луузан босож ... (Б.Р).
 - ... ойрын дөтлүүрийн чанадаас гарч ирсэн ... (Б.Р) гэх мэтчилэн туслах үгийн үүргээр орсон байх ба “Нанжинг автахын урьд өдөр нэгэн баг дайсны цэрэг хэрэм эвдрэн сүв гарсан газар дайран орсонд ... (Б.Р); ... тэр эхнэрийн зүг чиглэхэд ... (Б.Р); Нар шингэхийн алдад аргал авчирчээ. (Б.Р); Амьд байгаа цагтаа ах дүү бид тань ... (Б.Р); Монгол жанжин нар их тугийн хоёр хажууд сэлмээ сугалж зогсмогц ... (Б.Р); ... өргөн дэлгэр нутагт нь ард амьтан өвөлгүй зунаар, үхэлгүй мөнхөөр, өвчингүй үүрд, энх эсэн, санаа амар, сав дүүрэн жаргасан ... (Б.Р); Ма жанжин Ширчингийн ойр нэгэн тохилог газар олж аваад ... (Б.Р); ... тэмээний чанад талаас хааяа ганц нэг буу тас хийх төдий болтол ... (Б.Р); гэх жишээнд дэх “өдөр, зун, хажуу” гэх мэт хоёрдмол шинжтэй орон цагийн нэр “зүг, цаг, тал” гэх мэт орон цагийн утгат жинхэнэ нэр, “ойр” гэсэн орны утгат тэмдэг нэр нь жинхэнэ орон цаг буюу бүрэн бус хувилах цагийн нэрийн үүргээр түүний байрнаа орсныг анзаарч болно.

Ш.Лувсанвандан “монгол хэлний “ширээн-дээр, орон-доор” гэх мэтийн нийлбэрт тохиолдох “дээр, доор” гэх мэтийн орон цагийн харьцаа заасан үгсийг үгэлбэрийн доторх үгсийн хоорондын харьцаа заах дагавар үг (последлог) гэдэг нь хэрэг дээрээ өрнө дахины хэлний утгвар үг (предлог)-тэй адил үгсийн хоорондын харьцаа заах үүрэг гүйцэтгэдэггүй, харин өмнөх үндсээрээ хамжсан үгтэй хавсарч, орон заасан тогтворгүй нийлмэл үг бүтээж, үгэлбэрт хамтдаа нэг гишүүний үүрэг гүйцэтгэх ёстой үгсийн хоорондын харьцаа заах үүргийг, дараа нь орсон ил буюу тэг хэлбэрээр илрэх тийн ялгалын нөхцөл гүйцэтгэж байгаа хэрэг гэж үзэж болох мэт санагдана. Жишээлбэл, багшийн ширээн-дээр-0-0 олон ном байна² гэжээ. Тэрээр, “ширээн-дээр” гэдгийг “тогтворгүй нийлмэл үг” гэснийг бид “дээр” гэсэн орны нэр нь туслах үгийн үүргээр орж, задлаг хам бүтэц буюу хэлзүйжсэн хэлц болсон байх тул өгүүлбэрт “хаана, хаа” гэсэн асуултад хариулагдаж нэг гишүүн болно. Энэ бол захын дэлгэрүүлэгч орны байц гишүүний хэлзүйн хувьд дэлгэрэнгүй болсон хувилбар юм. (ширээн-д=ширээн дээр) Харин “дээр” гэсэн орны нэр нь ардаа өгөх оршихын тийн ялгалын саармагжсан тэг хувилбараар хэлбэржсэн гэвэл [ширээн дээр]-0 гэдэг нь найрах аргаар “байна” хэмээх өгүүлэхүүн гишүүнд захирагдах болно. Иймээс Ш.Лувсанвандан “дээр” гэсэн үг үгсийн хоорондын харьцаа заахад оролцохгүй, харин тогтворгүй нийлмэл үгсийн үндэс үүсгэхэд сүүлчийн элемент нь болж байна³ гэжээ. Тэрээр үгэлбэрийн гишүүн болсон нэг үг нь нөгөөтэйгээ заавал нэр буюу үйлийн аль нэг нөхцөлөөр хэлхэгдсэн байна гэж үзэж байна. Иймээс өгүүлбэрийн гишүүн хамжих аргаар холбогдохгүй болоход хүрнэ.

Нэр ба үйлийн аль ч нөхцөлөөр үл хувилах “хага, бут, өм, цуу, тас, цоо, нэвт, шувт, хуу, хэлт, год, бүлт, бяц, няц, хэмх, суга” гэх мэт дүрс дуурайх буюу дүрслэх үгс⁴, үйл хөдөлгөөний нүдэнд үзэгдэх, чихэнд сонсогдох, биед хүртэх байдлыг авиа дуурайх үгс (тас тас дуугар-, хон хон дуугар-, жин жин жингэнэ, нир нир нижигнэ, шир шир ор-, сэр сэр үлээ-, намьс намьс хийс-, ярс ярс алх-, жир жир жирвэгнэ-, луг луг лугш-, пар пар гүй-) нь үйл үгнээ тодотгох утгатай тэг үндсээр хамжин холбогдоно. Иймээс Ш.Лувсанванданы хэлснээр эдгээр үгс нь нөгөө үг (үйл үг Ч. Б)-ийн өмнө хамжин орж чадна. Нөгөө талаас тоо ба тэмдгийн нэр нь нэр ба үйл үгийн өмнө тодотгох утгатай тэг

² Лувсанвандан Ш. Орчин цагийн монгол хэлний бүтэц. Уб., 1968. 156-р т.

³ Лувсанвандан Ш. Орчин цагийн монгол хэлний бүтэц. Уб., 1968. 156-р т.

⁴ Базаррагчаа М. Монгол хэлний өгүүлбэр судлал. Уб., 2005. 182-р т.

үндсээр хамжин холбогдоно. Тэгвэл монгол хэлнээ нөхцөлөөр холбохоос гадна, тодотгох ба тодруулах утгатай тэг үндсээр хамжин холбох арга хэрэглүүр байсаар байна.

Орон цагийн харьцааны нэр нь хувилах үгс (N, V), үл хувилах үг (N^{adj.}, N^{num.}, N^{fig.}, N^{onom.}) гэсэн хоёр том бүлэг үгсийн дундын шинжтэй буюу хагас (заримдаг) хувилах тул

уулын өмнө	урьдын явдал, хойшдын үйлс, ашдын амьдрал, эртний улс
уулнаас урд	өмнөөс нь ир-, маргаашинаас хий-, тэндээс ав-, (маргаашидаа оч-)

гэх мэтээр харьяалах, гарахын тийн ялгалаар заримдаа өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржих ба өмнөх үгээ гарах, харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр захирна.

С.М.Трофимова монгол хэлнүүд дэх задлаг бүтцийн тухай бүтээлдээ “цэцэрлэг-ийн дотор, ширээ-ний дэргэд, өртөө-н дээр, цэцэрлэг-ийн дотроос, үд дунд, хашаа-н дотор, байшингууд-ын цаанаас, алхсан-ы дараа, зам-ын хажуугаас, хөшиг-ний ард, ор-ны ард, толгой дээр, газар дээгүүр, зүүн тийшээ, байшинг-ийн дотуур, агуулах-ын хажуугаарх замаар, хот тийшээ, ой-н дундуур, байшинг-ийн өмнө, цонх-н дор, хөл доогуур, мордо-х дээр, цуваа-н-аас гадна, хурл-ын дараа, тасал-сан-ы дараа, зам-ын дэргэдүүр, адуу-н дундаас”⁵ гэх мэт жишээг татаж, орон цагийн харьцааны нэр нь харьяалах, гарахын тийн ялгалаар өмнөх нэр болон цагт нэрийг хэлзүйн талаар захирах боловч утга үүргийн хувьд бие даасан шинжээ алдаж, туслах үгсийн үүргээр орж, задлаг бүтэц бий болдгийг нарийвчлан гаргажээ.

Д.А.Алексеев буриад монгол хэлний задлаг бүтцийг туслах буюу дагавар үгээр нь нэр (адли, багта, багаар, бэе, газаа, нюрган, салуу, тал, хүүл) ба жинхэнэ дагавар үг (собственно послелог)-ээр илэрдэг⁶ гээд жинхэнэ дагавар үгнээ “гадна, дээрэ, дээрэнээ, дээгүүр, дэргэдэ, доро, дороо, дороһоо, доогуур, дунда, дундаа, дундаһаа, дундуур, зуура, өөдэ, саана, сааша, саагуур, соо, сооһоо, соогоо, соогуур, тэндэ, туршада, тушаа, тээшэ, тээһээ, тээгүүр, урда, урид, урдаһаа, урдуур, хойноһоо, хойшо, хоорондо” гэх мэт орон цагийн харьцааны нэрийг оруулж, задлаг бүтэц үүсгэнэ гэжээ. Жич, “орондо, тул, төлөө, тухай, тухайтай, уруу, хамт, шахуу, шэнээн, шэнги, янзатай” гэх мэт дагавар үгс гэгчийг багтаасан байна. Д.А.Алексеев энэхүү задлаг бүтцээ утгаар нь орон ба цаг, адилтгасан ба хамтатгасан, шалтгаан ба зорилго, тоо ба хэмжээ, зэрэгцсэн ба орлосон утга илтгэнэ гэж үзсэн байна. Харин тэрээр 1941 оны бүтээлдээ энэ тухай дурдсангүй бөгөөд Ш. Барайшир дагавар үгийг утгаар нь дээрх байдлаар орон ба цаг, зорилго ба шалтгаан, адилтгах ба хүч нэмэх, тоо ба хэмжээ заах утгатай⁷ гэж үзсэн байна. Б. Х. Тодаева “дайн-ы өмнө, жил-ийн турш, бороо-н-оос өмнө, сар болсон-ы дараа” гэхчлэн орон цагийн харьцааны нэр нь өмнөх жинхэнэ нэр болон цагт нэрийг харьяалах, гарахын тийн ялгалаар захирдгийг ерөнхийд нь гаргасан байх⁸ ба Ц.Ж.Цыдыпов орны нэр нь туслах үүргээр орж, задлаг бүтэц үүсгэхдээ “юмын дээр/доор, юмсын дотор ба

⁵ Трофимова С.М. Падежно-послеложные конструкции монгольских языков и их русские эквиваленты. Новосибирск., 1989. стр 13-31

⁶ Алексеев Д.А. Послелог. Грамматика бурятского языка. Фонетика и морфология. М., 1962. стр. 301-316

⁷ Барайшир Ш. Орчин цагийн монгол хэлний дайвар үг. Уб., 1974. 30-46-р т.

⁸ Тодаева Б.Х. Грамматика современного монгольского языка. Фонетика и морфология. М., 1951. стр.161-162

гадна, юм руу зүглэх ба чиглэх (тушаа), хажуу ба тойрон” гэсэн орны утгыг илтгэдэг бол зэрэгцэх цагийн утга (дороо, зуура) илтгэнэ⁹ гэж үзсэний дээр “шалтгаан, хир хэмжээ, адилтгал, орлол боломж” зэрэг утга илтгэдэг тухай өгүүлсэн байна.

Г.Д.Санжеев, Д.А.Алексеев, Г.Ц.Пюрбеев, С.М.Трофимова, Б.Х.Тодаева нарын бүтээлээс үзвэл, төгс бус өгүүлэхүүний хэлзүйн хэлбэр болох задлаг бүтцийг бий болгоход орон цагийн харьцааны нэр идэвхтэй оролцдог болох нь тодорхой байна. Энэ талаар Е.К.Скрибник нэлээд судалгаа хийсэн ба өгүүлэхүүний гол бүрэлдэхүүн болох цагт нэр нь тэг үндэс буюу ерөнхийлсөн хэлбэр (обобщенная формула) гарах болон харьяалахын тийн ялгалаар хэлбэржин “дээрэхээ, хойно, хойшо, тээшээ, забһарта, зуура” зэрэг орон цагийн харьцааны нэрийг дагуулахаас гадна “цаг, үе, хир, зорилгоор, зэргээр, талаар, биеэр, зангаар, хэвээр, гуримаар, чигт, самбаанд, хажуугаар, оронд, зайгаар, сүүлээр, ёсоор” зэрэг орон цагийн утгатай жинхэнэ нэрийг дагуулдгийг буриад хэлний амьд жишээгээр нотлон үзүүлжээ.¹⁰ Мөн Б.Пүрэв-Очир төгс бус өгүүлэхүүний бүтцэд орон цагийн харьцааны нэр Ш.Лувсанвандангийн үзсэн шиг дагуул биш, гол бүрэлдэхүүн болж орсон “харуулахын хамт гэрчлэх, харах бүрий бахархах, хэлэхийн завсар бодох, хяхнах тутам уйтгарлах, үүр цайхын үес одох” гэх мэт холбоо үгийн жишээ татахын хамт “өнчин цагаан ботго нь ногоо гандаад ирэхийн цагт өөрийн хайрт ээжээ санаад ...; Түүнээс өмнөхөн аавыг түр зуур гарах хооронд хоёр лам бие биеэ харалцан ... Бурхны өмнө бадарч байсан зул бөхсөнөөс хойш нэлээд цаг удаж, шөнө дунд өнгөрөхийн орчимд гавж лам нэгэн зүүд зүүдлэв.” (Ц.Д) гэх мэт жишээ татан “Энэ мэт баримт сэлтийг үзэхэд орчин цагийн монгол хэлэнд нэг үгийг нөгөө үгтэй найруулан холбож харьцааны утга үзүүлэх “өмнө, дунд, гадна, өөд, уруу, дараа, доогуур, үес, талаар, хойно, дээрээ, турш, хойш, хажууд, дотор, зуур, дэргэд, цаана, завсар, (дагуу), даруй, тушаа, хооронд, орчимд, дараа гэх зэрэг олон тооны харьцааны нэр хэрэглэж байгаа нь харагдаж байна”¹¹ хэмээжээ.

“-гу, -үә, -үси~си, -на, -үйр, -де, -ге, -и” дагавраар бүтсэн орон цагийн харьцааны нэр нь цуваа бүтцэд туслах үүргээр орсон болохоос бие даасан “дагавар үг” хэмээх үгсийн ай болохгүй юм. Эдгээр орон цагийн харьцааны нэр нь:

I. 1-рт, хэлзүйжсэн холбоо үг бүтээнэ. (гэрийн гадаа, гэрээс гадагш, гэрийн инад, гэрээд чанад, гэрийн гадна, гэрийн гадуур)

2-рт, төгс бус өгүүлэхүүн нь хэлзүйжсэн холбоо үгээр бүтнэ.

-Лавлаж асуувал, үүр завсарлахаас нааш найр тарахгүй гэнэ билээ. (Б.Р) Чи нэг хоол хийх зуураа сургуульдаа очоод ир. (Л.Мишиг) Нэлээн унтсаны дараа морь нь цавчлан сэрээв. (Л.Мишиг) Хоёр зуун чоно авласны гадна өдий төдий ажлыг явуулав. (Г.Д.Санжеев) Тоог үсгээр бичихээс гадна бас тусгай тэмдгээр тэмдэглэнэ. (Г.Д.Санжеев) Гарт орсон хойно хэвтэхээс өөр хэрэг үгүй. (Г.Д.Санжеев) Өдий төдий тариачингийн ажлыг явуулсны дээр малын ажлыг эрхэлнэ. (Г.Д.Санжеев) Сүрэн орос хэлтэйн дээр хятад хэлийг мэднэ. (Г.Д.Санжеев) Оройн хоол хийх дээр далайгаас нөгөө том хар юм бас л гарч ... (Г.Д.Санжеев) Тус ажлаа гүйцэтгэсний дараагаар худаг малтах ажилд орно. (Г.Д.Санжеев) Бороо орсны дараа газрын өнгө сайхан боллоо. (Г.Д.Санжеев)

⁹ Цыдыпов Ц.Ж. Аналитические конструкции в бурятском языке. Улан-Удэ., 1972. стр. 250

¹⁰ Скрибник Е.К. Полипредикативные синтетические предложения в бурятском языке. Новосибирск, 1988. стр. 92-126, 185-190

¹¹ Пүрэв-Очир Б. Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүйн холбох тогтолцоо. Уб., 1988. 50-52-р т.

Их улсад хүрэхийн урьд захын бэлчирт хүрэв. (Г.Д.Санжеев) Гэгээн нь *ирэхээс урьд* зайлъя. (Г.Д.Санжеев) *Донгодсон хойно* бүгд улс тархав. (Г.Д.Санжеев) Нэгэн хэсэг аймаг улс *байсны дотор* янаглаж огт үзээгүй тэнэг хөвүүн байж. (Г.Д.Санжеев) Хүн хэдий сайн ч *хэлэхээс нааш* санахгүй, цаас хэдий нимгэн ч *хатгахаас нааш* цочрохгүй.

3-рт, төгс өгүүлэхүүнийг “гэ-, хэмээ-” үйл үг нь хэлзүйжсэн холбоо үгээр бүтэж болно. жишээ нь: Намайг нүдээ хар *гэхээс нааш* харж болохгүй. Ирнэ *гэсэн хойно* ирэлгүй хаачхав” гэх мэт.

Жон Стрийт 1. бүр, болгон, бүхэн, тутам, тусам (unit quantifiers) өдөр болгон усанд умбаж наадав, өдөр тутмын сонин, өдөр бүрийн амьдрал, хүн бүхэн үүнийг мэдэх ёстой, гэр болгон гурван цонхтой, бүстэй болгон нь явсан, Тэнд янз бүрийн улс байсан, айл бүрд, Нураахмэд гуай энэ бүхнийг товчхон өгүүлсэн. 2. илүү, гаруй, шахам, орчин=орчим (measure quantifiers) жил илүү болж байна, сар гаруй, хоёр өдөр, хүн бүр шахам, өдөр бүр шахам¹² гэх мэтээр жишээг гаргаж онцлог шинжийг нь өгүүлсэн. Энэ нь монгол хэлэнд бүхэл хэсэг заасан холбоо үг үүсгэхэд

А. N^{sub} (цагийн утгат жинхэнэ нэр) буюу $N^{place-time}$ + бүхэн

жил бүхэн, улирал бүхэн, сар бүхэн, өглөө бүхэн, өдөр бүхэн, орой бүхэн, шөнө бүхэн гэх мэт.

Б. нөгөө + N^{sub} (цагийн утгат жинхэнэ нэр)

нөгөө тал (нөгөө талын, нөгөө талд, нөгөө талыг, нөгөө талаас, нөгөө талаар, нөгөө талтай, нөгөө тал руу, нөгөө тал шиг), нөгөө зах (нөгөө захын, нөгөө захад, нөгөө захыг, нөгөө захаас, нөгөө захаар, нөгөө захтай, нөгөө зах руу), нөгөө тэр жилийн, нөгөө тийшээ

В. энэ + N^{sub} (цагийн утгат жинхэнэ нэр) буюу $N^{place-time}$

энэ зах, энэ тал, энэхэн тал, энэ зүг, энэ орчим, энэ зуур, энэ дээр, энэ дээгүүр, энэ доор, энэ доогуур, энэ дээш, энэ доош, энэ дотор, энэ хойно, энэ хойгуур, энэ хойш, энэтээ тийш, энэ агшин, энэ үе (энэ үеийн, энэ үед, энэ үеийг, энэ үеэс, энэ үеэр, энэ үетэй, энэ үе рүү, энэ үе шиг), энэ жил, энэ он, энэ улирал, энэ сар, энэ өглөө, энэ өдөр, энэ орой, энэ шөнө

Г. тэр + N^{sub} (цагийн утгат жинхэнэ нэр) буюу $N^{place-time}$

тэр зах, тэр тал, тэрхэн тал, тэр зүг, тэр орчим, тэр зуур, тэр дээр, тэр дээгүүр, тэр доор, тэр доогуур, тэр дээш, тэр доош, тэр дотор, тэр хойно, тэр хойгуур, тэр хойш, тэр агшин, тэр үе (тэр үеийн, тэр үед, тэр үеийг, тэр үеэс, тэр үеэр, тэр үетэй, тэр үе рүү, тэр үе шиг), тэр жил, тэр он, тэр улирал, тэр сар, тэр өглөө, тэр өдөр, тэр орой, тэр шөнө, тэр дор, тэр дороо, тэр дороос, тэр чигээрээ, тэр дунд, тэр дундуур, тэр дундаас, тэртээ хол, тэртээ алсаас, тэртээ газар, тэртээ хойно, тэртээ өмнө, тэртээ зүүн зүг, тэртээ баруунаа, тэртээ тийш гэх мэт.

Орон цагийн харьцааны нэрийн зэрэгцсэн ба угсарсан харьцаа нь монгол хэлний хоршоо үгээс ч ажиглагддаг.

А. $N_{sub} \leftarrow N_{place-time} \rightarrow V$

Б. $N_{place-time} \leftarrow N_{sub} \rightarrow V$

В. $N_{place-time} \leftarrow V$

Орон цагийн харьцааны нэр нь өмнөх нэр үгээ харьяалахын тийн ялгалаар захирна.

А. ялгасан тохиолдолд ил хэлбэрээр илэрнэ.

¹² Street John C. Khalkha Structure. Bloomington. 1963. p.177-178

Жишээ нь: эдүгээгийн өмнө, өвлийн дараа, цагийн урьд, давын өмнө, намрын дараа, хаврын өмнө, намрын өмнө, зуны дараа, зуны өмнө, хаврын дараа, өвлийн өмнө, давааны ар, давааны ард, уулын өвөр, голын дээд, голын доод, голын дунд, замын дунд, замын дундуур, сарын дунд, сарын дундуур, сарын хойно, голын дэргэд, сэтгэлийн дотор, ахын хажууд, ээжийн дэргэд, аавын зэрэгцээ гэх мэт.

-Хамба: Үгүй яагаад хэдхэн сарын өмнө мэрэг төлөг буулгуулж байсан улс өөр болчихов (Д.Нам). -Данзандаш: Ёстой хэдхэн хоногийн дотор хоггүй болгож чадна (Д.Нам). -Жалцан... Тэр мэтийн овилгогүй хүн, энэхэн хэдэн жилийн дотор бүр зэрэг тушаалтай болохыг бодоход...(Д.Нам). -Арван жилийн өмнө бол хүний бодлогод багтан орох байтугай зүүдэнд ч орж болохгүй юмыг одоо нүдээрээ үзэж, чихээрээ сонсож байгаа чинь гэгээн засгийн минь ач байна шүү дээ (Д.Нам). -Жалцан: Одоо яая гэх вэ, ардын засгын ажил ихийн дээр Дагва ирээд л яахын аргагүй ийм болчихлоо (Д.Н).

-Дэжид: Би ч дотроо зөвшөөрөх за яах вэ дээ, юм л сурвал барав гэж бодож байна. -Бие нарийхан хээнцэрлэн хөдлөх нь түргэн бөгөөд зурвас хөмсгийн доорхи урт сормуусны дунд хар цагаанаар эргэлдэх дугираг нүд хийгээд тунгалаг царайг нимгэн улаан уруулын цаанаас гэрэлтэн харагдах цагаан шүд (Д.Нам). -Очир: бухимдан чангаар “Эдүгээ өчүүхэн бага буурай улс орон минь Оросын хоёр намын хооронд хавчуулагдан сүйрсээр ирснийг журмын нөхөд ухааран мэдэж, улаан оросоос холбоогоо даруй таслан цааш ирэхийг итгэмжлэн сануулсугай (Д.Н).

-(N_{pronoun}^{gene.} ← N_{place-time}) /миний наана, чиний наана, тэрний наана, түүний наана, тэдний наана, түүний цаана, тэрний цаана, үүний урд, үүний ард, тэрний өмнө, тэрний хойно, энэний урд, энэний хойно, эдний дараа, эдний өмнө, эдний өмнө, тэдний өмнө, миний хойно, чиний урд, бидний доор, миний доор, тэдний доор, тэрний хойно, түүний дотор, тэрний гадар, миний хажууд, чиний дэргэд/

Дэмбэрэл- ...Түүний хажуугаар манай аав тачигнахаар мөн ч инээдтэй болоод байна шүү (Д.Нам). -Нөгөө талдаа бурхантай бөгөөд түүний өмнө ламын хийсэн гүрмийн балин байгаа харагдана. (Д.Нам). - Пагма: ... Чиний хойноос бөөн уур манан болж гараад өөрөө алга. (Д.Н).

Б. үл ялгасан тохиолдолд тэг хувилбараар илэрнэ.

Жишээ нь: гэр дотор, тосон дээр, айрган дээр, элсэн дээр, буурин дээр, хацар дээр, нүдэн дээр, духан дээр, нүүрэн дээр, дэрэн дээр, хөвөөн дээр, над дээр, дэвтэр дээр, зулай дээр, дэлхий дээр, чулуун дээр, булшин дээр, хоншоор дээр, өлгий дээр, шандан дээр, сандал дээр, орон дээр, торхон дээр, дөрөөн дээр, авдар дээр, газар дээр, өвөр дээр, зам дээр, залуур дээр, хорвоо дээр, цогцон дээр, харгуй дээр, малгай дээр, алган дээр, цаасан дээр, нуруун дээр, тавган дээр, эмээл дээр, өрхөн дээр, даваан дээр, овоон дээр, хуудсан дээр, тавцан дээр, эргэн дээр, шарил дээр, яндан дээр, мөчир дээр, дээвэр дээр, шугаман дээр, суман дээр, гараан дээр, гавьяан дээр, сэтгэл дээр, итгэл дээр, наран дээр, мандал дээр, уулан дээр, сайран дээр, чам дээр, уяан дээр, өвөр дээр, найран дээр, газар доор, сэтгэл дотор, байшин дотор, сандал доор, энэ урд, энэ ард, тэр урд, энэ ард, гар доор, таазан доор, дэвгэр доор, дэрэн доор гэх мэт.

В. тухайн үг эгшгээр төгссөн болон заримдаа “-н” –тэй тохиолдоно.

Жишээ нь: /толгойн дээр, хоолойн дотор, эгнээн гадна, баганаан дотор, ачаан дотор/ нуруун дээрээс ачаа авах шиг боллоо. тэмээн дээрээс- тэмээн дээрээс наран

ойрхон, -*Тайзан дээр* шавар байшингийн дотоод тал, хананд хир буртаг болсон хуучны зураг хадсан байна. (Д.Н)

$-N_{\text{place-time}}^{\text{gene.}} \leftarrow N_{\text{sub.}}$

Өмнөхийн эсрэгээр жинхэнэ нэр нь өмнөх орон цагийн харьцааны нэрээ харьяалахын тийн ялгалаар захирна. Жишээ нь: *оройн зоог, маргаашийн хурал, дээрийн хүн, хоорондын явдал, дотрын өвчин*

$-N_{\text{sub}}^{\text{abl}} \leftarrow N_{\text{place-time}}$

(*дээр, доор, наана, цаана, урд, урьд, баруун, дэргэд, хоорондоос, эдүгээ, урд, ард, өөд*)

...*үүнээс хойш* гадаад дүрс байдлаа өөр болгож байгаа (Д.Нам). -Данзандаш: ... *Үүнээс хойш* аяга тавагт гараа битгий хүргэж бай (Д.Нам)

$-N_{\text{pron.}}^{\text{abl.}} \rightarrow N_{\text{place-time}}$

-Жамсран – *Түүнээс гадна* шөнө ажил хийж байх үед гэнэт Түшигийн хүү үхэр *дундаас босоод* гүйсэн юм (Д.Нам)

$-N_{\text{place-time}}^{\text{abl.}} \leftarrow V$

-Дагва: Танайх *эндээс нүүгээд* илүү ногоотой газар олж малын тарга хүч ч сайжрахгүй, харин эндхийн сайхан ургац ногоо дэмий хаяагдана шүү дээ (Д.Нам)

-Балжир: Эрхэмүүд, *хаанаасаа хааш* нь явж байна вэ? (Д.Нам)

$-N_{\text{sub}}^{\text{adit.}} \leftarrow N_{\text{place-time}}$

(*урагш, хойш, нааш, цааш, доош, дээш, баруунш, тийш, арагш, хааш, гадагш, дотогш, доромш, умарш, баруун тийш, баруунчаа*)

$-N_{\text{num.}} \leftarrow N_{\text{place-time}}$: *хоёрын хооронд, гурвын дунд*

$-N_{\text{place-time}} \leftarrow N_{\text{place-time}}$

“маргаашийн дараа, нөгөөдрийн маргааш, маргаашийн дээр” гэх мэтээр хэлбэрийн хувьд тохиолдохоос гадна утгын талаас харьяалахын тийн ялгал нь тухайн орон цагийн харьяа хамааны утга, мөн юмс үзэгдлийн орших орон, цаг хугацааны хувиарлалтыг гаргахад чухал ач холбогдолтой.

$-N_{\text{place-time}} + \text{“-х”} + N^{\text{case}}$ (*хойнох нь ир-, хаанахын, хойнох айл, удаах хүн, дараах асуудал*)

$-N_{\text{place-time}} + \text{“-уул, -чуул, -тан”} + N_{\text{sub.}}$ (*хойдуул, хойдчуул, баруунтан, зүүнтэн*)

$-N_{\text{place-time, pron.}} + \text{“-хан”} + N_{\text{place-time}}$

(*энээхэн зүүнтээ, энүүхэн энд, тэрүүхэн тэнд, энүүхэн баруунтаа, тэрүүхэн зүүнтээ*)

-Гавармаа: Жаахан дээхэнтэй нь... (Д.Н); -Гавармаа: Түүний чинь *зүүхэнтэй* нь энэ толинд хар. (Д.Н); -Түшиг: *Энээхэн зүүнтээ* тэр хэдэн цахилдагны тэнд гэж боддог юм. (Д.Н); -Жамсран: ... Уг нь хамтарвал сайн сан. “дал мөрөө хөдөлгөж” ёо ёо, нужигнаж байгаагий нь ... хичнээн өвчтэй гэж санана чи, заримдаа нойргүй хонуулна шүү. (Д.Н)

$-N_{\text{place-time}} + \text{“-оо”} + V$;

Дэжид – Би ч *дотроо зөвшөөрөх* за яах вэ дээ, юм л сурвал барав гэж бодож байна. (Д.Н)

Монгол хэлний орон цагийн харьцааны нэрийг өгүүлбэр зүйн талаас судалсан эрдэмтэд байц гишүүн гэж үзэж байсан бол М.Базаррагчаа үүр өндгийн харьцаан дээр өгүүлбэрийн гишүүдийг ангилсан¹³ байна. Үүнээс үзвэл, орон цагийн харьцааны нэр нь

¹³ Базаррагчаа М. Монгол хэлний өгүүлбэр судлал. Уб., 2005. 209-р т.

захын дэлгэрүүлэгч буюу өгүүлбэрийн гол утгад нэмэн дэлгэрүүлэх үүрэгтэй бөгөөд хэлбэрийн хувьд хувиран өгүүлбэрт янз бүрийн байранд тохиолдож энгийн ба нийлмэл өгүүлбэрийн гишүүн болох нь хэлний феноменлогийн үзэгдэлтэй холбогдоно гэж болно.

Орон цагийн харьцааны нэрийг хэлзүйн талаас нь хувилах эс хувилах дээр нь бусад үгсийн аймгаас ялгах боломжтой бол өгүүлбэрт үйл үгнээ захирагдаж тодруулагч буюу детерминант хэлбэрээр тохиолдоно. Орон цагийн харьцааны нэр нь хэл зүйн хувьд ил ба далд хэлбэрээр тийн ялгалаар холбогдож холбоо хоршоо үгийн түвшинд илэрч байгаа ч өгүүлбэрийн хүрээнд орон цагийн харьцааг бүхэлд нь заах онцлогтой юм. Орон цагийн харьцааны нэр нь нөхцөл бүтээврийн үүргээр тохиолдоно. Өмнөх үеийн хэл шинжээчид дагавар үгийн үүргээр орсон эсвэл дайвар үг, сул үгт оруулан үзсэн тул ихэвчлэн байц гэж үзсэн. Тухайлбал зарим эрдэмтэд дагавар-дайвар үг, нэр-дайвар үг, дайвар-дагавар үг гэх зэргээр нэрлэж байсан.

Эрдэмтэн Д.А.Алексеев дагавар үгийн айд, Б.Х.Тодаева дайвар үг, дагавар үгийн аль алинд хамруулж үзсэн бол Н.Дыренкова бие даасан ай гэж үзсэн байна.

Харин бид орон цагийн харьцааны нэр нь өгүүлбэрт дагавар үгийн үүргээр орж нөхцөл бүтээврийн үүргээр тохиолдохоос дагавар буюу сул үг биш гэж үзэв. Мөн орон цагийн харьцааны нэр нь тодотголын байранд тодотгогчийн үүргээр тохиолдоно.

Мөн нийлмэл өгүүлбэр дэх орон цагийн харьцааны нэрийн хэрэглээний онцлогийг дараах жишээнээс тодруулан үзэж болно. Жишээлбэл, *-Гаднаас Дэлгэрийн хүү Мөнхөө орж ирж амар мэндийг нь асууна. -Данзандаш: ...Удахгүй зүгээр болох байх.-Дараа нь Нямдорж гарч ирэх бөгөөд гар боодолтой, гунигтай царайгаар доош ширтэн алгуур гишгэлэн явснаа ширээний өнцөг мөргөн зог тусаад дороо байгаа хогийн савыг зориуд өшиглөнө. -Дараа нь их дайны тулаанд тасралтгүй явсаар энд ирсэн минь жирийн хэрэг биш, аугаа хүчин дээд тэнгэрийн зохиол билээ. Өгүүлбэрийн эхэнд орон цагийн харьцааны нэр тохиолдох ба гэхдээ нийлмэл өгүүлбэрийн холбоос, цогцолборын холбоос болох онцлогтой байна.*

Эндээс товчхон дүгнэж үзвэл орон цагийн харьцааны нэр нь өнгөн бүтэц буюу утгын хувиргалын талаас хоршоо ба шууд бус нэрлэлтнээс утга, бүтэц, үүрэг, хэрэглээний онцлог нь тодорхой харагдаж байна.

Харин хэлбэрийн хувиргалын хувьд өмнөх үгээ харьяалах, гарахын тийн ялгалаар захирах боловч утгын хувьд орон цагийн утгат тийн ялгалын үүргээр орж, задлаг хам бүтэц үүсгэдэг. Жишээ нь: “Туул голын/-оос хойно, урд ... очсон/-ы/-оос хойш” гэх мэтээр туслах үгийн үүргээр ордог. Үүнийг уламжлалт хэл шинжлэлд “дагавар үг” гэсэн бие даасан үгийн ай болгодог байв. Бидний санавал, орон цагийн харьцааны нэр нь өөр үүргээр орсон болохоос биш “дагавар үг” биш юм. Ирэхтэй зэрэг/хамт, явсан учир-аас, очдогтой адил, ирэхийн сацуу, эх орныхоо төлөө, уншсан тухайгаа, хэлсэн ёсоор, очихын оронд, голын дагуу, дайсны эсрэг, гэрийн зүг (Г.Д.Санжеев (1953), Б.Х.Тодаева (1951), Н.Н.Поппе (1937), Ш.Барайшир (1958), Ш.Лувсанвандан (1956) гэх мэт холбоо үгнээ “зэрэг, учир, чинээ, төлөө, тухай, ёс, ор, зүг” зэрэг жинхэнэ нэр, “адил, сацуу, эсрэг” зэрэг тэмдэг нэр, “хамт” гэсэн төлөөний үг нь туслах үүргээр орсон болохоос, бие даасан “дагавар үг” болохгүй юм. Мөн өгүүлбэрт орон цагийн ойлголтыг илэрхийлэхэд орон цагийн харьцааны нэр нь тодотгол, тодруулагч гишүүн болдог байна.

НОМ ЗҮЙ:

- Алексеев Д.А (1962), Послелог. Грамматика бурятского языка. Фонетика и морфология. М.,
- Базаррагчаа М (2005), Монгол хэлний өгүүлбэр судлал. Уб.,
- Барайшир Ш (1974), Орчин цагийн монгол хэлний дайвар үг. Уб.,
- Лувсанвандан Ш (1968), Орчин цагийн монгол хэлний бүтэц. Монгол хэлний үг нөхцөл хоёр нь. Уб.,
- Пүрэв-Очир Б (1988), Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүйн холбох тогтолцоо. Уб.,
- Скрибник Е.К (1988), Полипредикативные синтетические предложения в бурятском языке. Новосибирск.
- Street John C (1963), Khalkha Structure. Bloomington.
- Тодаева Б.Х (1951), Грамматика современного монгольского языка. Фонетика и морфология. М.,
- Трофимова С.М (1989), Падежно-последовательные конструкции монгольских языков и их русские эквиваленты. Новосибирск.
- Цыдыпов Ц.Ж (1972), Аналитические конструкции в бурятском языке. Улан-Удэ.

SUMMARY

The peculiarities of meaning and structure of place-time relative nouns were categorized by studying their deep, surface, nuclear and transformative structures.

As for transformative structure, the functions of morphemes, compound words and sentences are vital. For the grammatical transformation: (1) grammatical compound words are derived from place-time relative nouns; (2) incomplete predicates are formed by grammatical compound words; (3) verbs “гэ-, хэмээ-” can be derived from grammatical compound words.